

## ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн тухай журмын төсөл

### **Журмын төсөл боловсруулсан шаардлагын талаар:**

Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ыг баталж тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж ирсэн. Гэвч Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн чиг хандлагад нийцүүлэн үнэт цаасны зах зээлд оролцогчдод тавигдах шалгуур, нөхцлийг өндөрсгөх шаардлагатай байна. Тухайлбал өнгөрсөн 2011 онд 40 компанид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон нь зах зээлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой ч зохицуулалттай этгээдэд тавигдах шаардлага төдийлөн өндөр биш учир санхүүгийн үйлчилгээний эрсдлийг нэмэгдүүлж байна.

Иймд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн мэргэжлийн, ёс зүйн болон санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, ингэснээр үйл ажиллагааны эрсдлээс сэргийлэх үүднээс журмыг шинэчлэн найруулсан болно. Мөн шинэчлэн найруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд түүнд нийцүүлэн журмын зохицуулалтын агуулга, нэр томъёог өөрчлөх шаардлага үүссэн.

### **Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Уг төслийг боловсруулах явцад Сангийн яам, Төв банкны журмын бүтэц, зохион байгуулалт, суурь зарчим болон Хорооноос даатгал, бичил санхүүгийн салбарт олгож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой журмуудыг судлав.

Журмын төсөл нь 14 бүлэг, 6 хавсралтаас бүрдэх бөгөөд дор дурьдсан харилцааг зохицуулна. Үүнд:

1/ Нийтлэг үндэслэл бүлэгт үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулахад баримтлах зарчим, үйлчлэх хүрээ, хязгаар, болон зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны ялгаа, заагийг тодорхойлж, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

2/ Хоёрдугаар бүлэгт тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг багтаав.

3/ Гуравдугаар бүлэгт тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай бүрдүүлэх бичиг баримтуудыг тодорхойлно.

4/ Дөрөвдүгээр бүлэгт журмын төсөлд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн бичиг баримтийг хянах үйл ажилбарыг загварчилан, чанаржуулах үүднээс нэмж оруулсан болно.

5/ Тав, долоо, найм, ес, арав, арван нэг, арван хоёрдугаар бүлэгт үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, салбар байгуулах, дүрмийн сангийн хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүтцэд өөрчлөлт оруулах, оноосон нэр өөрчлөх, гүйцэтгэх захирал томилох үндэслэлийг тодорхойлно. Мөн Хорооны бүрэн эрх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг заана.

6/ Зургадугаар бүлэгт үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тохиолдолд Ажлын албанд ирүүлэх бичиг баримтын давхардлыг арилгаснаар хянах ажиллагааг чанаржуулах үүднээс нэмж оруулав.

7/ Арван гуравдугаар бүлэгт тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх хууль зүйн үр дагавар, холбогдох этгээдийн хүлээх хариуцлагыг тусгав.

8/ Арван дөрөвдүгээр бүлэгт үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтны тохиромжтой этгээдийн шалгуурыг нэмж оруулав.

9/ Арван тавдугаар бүлэгт Үнэт цаасны зах зээлийн тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлно.

### **Журмын төсөл батлагдсанаар үүсэх үр дагавар:**

Уг журмын төсөл батлагдсанаар үнэт цаасны зах зээлийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хавсралтад заасан санхүүгийн болон тохиромжтой этгээдийн шалгуурыг мөрдүүлэн өндөрсгөх замаар зах зээл дэх эрсдлийг бууруулах ба бичиг баримтыг хянах, тусгай зөвшөөрлийг сунгах ажиллагааг тордруулснаар хяналтын давхардал буурах нөхцөл бүрдэнэ.

### **Журмын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах талаар:**

Журмын төслийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлсэн бөгөөд уг журамтай уялдуулан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэх төсөл хийгдсэн.

Хорооны 2006 оны 29-р тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” болон шинэчилэн найруулсан журмын төсөлд оруулсан нэмэлт өөрчлөлт:

№	Шинэчилсэн журмын төсөл	Хорооны 29-р тогтоолоор батлагдсан журам	Тайлбар
1	2.1.2. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь байгууллагууд өөрийн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг энэхүү журмын хавсралтын дагуу хангаж ажиллана.	-	Нэмэлт
2	Дөрөв. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бичиг баримтыг хянах	-	Нэмэлт
3	Зургаа. Тусгай зөвшөөрлийг сунгах	-	Нэмэлт
4	Арван дөрөв. Тохиромжтой этгээдийг тодорхойлох		Нэмэлт

### **ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**

## **Холбогдох хуулийн заалтууд:**

### **Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль**

5.3. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

11.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ :

11.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл

11.1.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

11.1.3. тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар

11.1.4. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

11.1.5. тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос шалтгаалан хуульд заасан бусад баримт бичиг

15.3.5. андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах

18.1. Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан захиргааны шийтгэл ногдуулна:

18.1.1. энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20000 - 50000, хуулийн этгээдийг 100000 – 250000 төгрөгөөр

18.1.4. хуурамч бичиг баримт бүрдүүлж тусгай зөвшөөрөл авсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20000 – 50000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

### **Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль**

6.1.2. бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох

#### **Үнэт цаасны зах зээлийн тухай хууль**

19.1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага нь үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах Хөрөнгийн бирж, Дилерүүдийн арилжааны төв, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага, хамтын хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын сан, брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх компани байна.

19.2.11. болзошгүй эрсдлээс хамгаалах сантай байх. Сангийн эх үүсвэр нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгө болон үйл ажиллагааны ашиг байна.

20.4. Энэ хуулийн 20.1-д заасан тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай1 хуульд зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргана:

20.4.1. хуулиар тогтоосон хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг хангасан байдал;

20.4.2. компанийн дүрмийн баталгаажуулсан хуулбар;

20.4.3. эхний 3 жилийн төлөвлөгдөж буй ашгийг тусгасан бизнес төлөвлөгөө;

20.4.4. үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тухайд Хөрөнгийн бирж, эсхүл Дилерүүдийн арилжааны төвийн арилжааны сүлжээтэй үйл ажиллагаагаа хэрхэн

уялдуулах талаархи дэлгэрэнгүй танилцуулга;

20.4.5. хувьцаа эзэмшигчийн төлбөрийн чадвар, банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт;

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.4.6. эрсдлийн менежментийн төлөвлөгөө;

20.4.7. мэргэжил, мэргэшлийн дадлага туршлагатай боловсон хүчнээр хангагдсан байдал;

20.4.8. орон байр, техник, тоног төхөөрөмжийн хангалт, цахим тоолуурын сүлжээнд холбогдсон байдал.

34.1.3. эрх хэмжээнийхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж мөрдүүлэх;

38.1. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна.

### **Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль**

6. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1/ гадаадын хөрөнгө оруулагч дангаараа аж ахуйн нэгж байгуулах;

2/ гадаадын хөрөнгө оруулагч монголын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;

3/ гадаадын хөрөнгө оруулагч тус улсын аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авах замаар шууд хөрөнгө оруулалт хийх.

### **Компанийн тухай хууль**

13.Шинээр компани үүсгэн байгуулах

16.Компанийн дүрэм

18.Компанийг өөрчлөн байгуулах

### **Банкны тухай хууль**

6.2.7.харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ;

6.4.Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг банк, түүний хараат болон охин компанид тухайн үйл ажиллагааг эрхлэхэд Монголбанк татгалзахгүй тухай бичгээр мэдэгдсэн тохиолдолд олгож болно.

## **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд /цаашид “зохицуулалттай этгээд” гэх/-д тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, салбар байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, оноосон нэр өөрчлөх, эрх бүхий албан тушаалтан томилох зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмын 1.4.1-1.4.10, 1.4.16-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг энэ журмаар, 1.4.11-1.4.15-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг тус тусын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журмаар зохицуулна.

1.3. Тусгай зөвшөөрлийг олгохдоо үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримталж буй бодлого, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны ашиг сонирхлын хамгаалах, ил тод, үр ашигтай, шударга байх зарчмыг баримтална.

1.4. Хорооноос зохицуулалттай этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалтад заасан дараах зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

- 1.4.1. үнэт цаасны брокерийн;
- 1.4.2. үнэт цаасны дилерийн;
- 1.4.3. үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн;
- 1.4.4. андеррайтерийн;
- 1.4.5. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн;
- 1.4.6. үнэт цаасны арилжааны тооцооны;
- 1.4.7. үнэт цаасны арилжааны төлбөрийн;
- 1.4.8. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн;
- 1.4.9. үнэт цаасны арилжаа эрхлэх;
- 1.4.10. харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ”
- 1.4.11. хөрөнгө оруулалтын сангийн;
- 1.4.12. хөрөнгө оруулалтын менежментийн;
- 1.4.13. үнэт цаасны итгэмжлэн удирдах;
- 1.4.14. кастодианы;
- 1.4.15. санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох;
- 1.4.16. Хорооноос зохицуулалттай гэж тооцсон бусад.

1.5. Дараах зохицуулалттай үйл ажиллагааг хавсарч эрхэлж болно:

1.5.1. брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд дилерийн болон андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг;

1.5.2. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд кастодианы, тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааг;

1.5.3. кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагааг;

1.5.4. кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд төлбөрийн үйл ажиллагааг;

1.5.5. тухай бүр Хорооноос зөвшөөрсөн үйл ажиллагаа.

1.6. Энэ журмын 1.4-д зааснаас бусад үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно.

1.7. Энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй хэд хэдэн үйл ажиллагааг нэг зохицуулалттай этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлж тооцно.

1.8. Зохицуулалттай этгээд нь зөвхөн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхлэх бөгөөд эдгээрээс өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

1.9. Энэ журмын 1.7 дахь заалт банкинд хамаарахгүй.

1.10. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16-д зааснаар Хороонд бүртгүүлсний дагуу гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг эрхэлнэ.

1.11. Гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээд гэж гадаадын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн оролцогч байгууллагад гадаадын иргэн, аж ахуйн нэгж хөрөнгө оруулсан зохицуулалттай этгээдийг хэлнэ.

1.12. Шашны болон төрийн бус байгууллага мэргэжлийн оролцогч байгууллагад аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах, хувьцааг эзэмших үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

1.13. Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаагаа байнгын, тасралтгүй явуулна.

1.14. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

1.15. Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан этгээдийг ойлгоно.

### **Хоёр. Зохицуулалттай этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага**

2.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. Компанийн тухай хуулийн 13, 18-д заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар хувьцаат компани (ХК) болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн (ХХК) хэлбэрээр байгуулсан байх;

2.1.2. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд өөрийн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг энэхүү журмын 8 дугаар хавсралтын дагуу хангаж ажиллана. /Энэхүү заалт

нь үнэт цаасны арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх компанид хамаарахгүй/

2.1.3. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос мэргэжлийн эрх олгох журмын дагуу эрхлэх ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан байх;

2.1.4. Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байх бөгөөд тухайн ажилтан нь энэ журмын 2.1.3-д заасан эрх авсан, гүйцэтгэх захирал, брокер, дилер, үнэлгээ, төсөл, судалгаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлийн ажил үүргийг хавсран эрхэлдэггүй байх;

2.1.5. Зохицуулалттай этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч /хувьцаат компанийн хувьд нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид/, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх захирал, дотоод хяналтын ажилтан болон мэргэжилтнүүд нь дараах шалгуурыг хангасан байна:

2.1.5.1. эдийн засгийн болон санхүүгийн үйл ажиллагааны эсрэг гэмт хэргээр шийтгэгдээгүй байх;

2.1.5.2. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;

2.1.5.3. сүүлийн 5 жилд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад ажиллаагүй байх;

2.1.5.4. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд өөр байгууллагад үндсэн ажилтнаар давхар ажил, хөдөлмөр эрхэлдэггүй, өөр зохицуулалттай этгээдийн 5 хувь ба түүнээс дээш хувийг эзэмшдэггүй байх;

2.1.5.5. энэ журмын 14 дүгээр зүйлд заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байх;

2.1.6. зохицуулалттай үйл ажиллагаанд үүсч болзошгүй ашиг сонирхолын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журамтай байх;

2.1.7. харилцагчдыг хүлээн авч үйлчлэх байрыг брокероос бусад ажиллагсдын албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байна. Ажилтны тоонд тохирсон шаардлага хангахуйц албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж, компьютер, принтер, хувилагч, бичлэг хийх боломжтой утас, факсын аппаратаар хангагдсан байх;

2.1.8. програм болон техник хангамж нь тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагааны дотоод журам, Хорооноос тогтоосон мэдээллийн нэгдсэн сангийн журам, нягтлан бодох бүртгэлийн зааварт заасан шаардлагад нийцсэн, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргах бүрэн боломжтой бөгөөд харилцагчтай байгуулсан гэрээ, харилцагчийн бүртгэл, тэдний хөрөнгийн хөдөлгөөнтэй холбогдох гүйлгээний мэдээллийг хадгалах боломжтой байх;

2.1.9. гадаадын хөрөнгө оруулагч дангаараа хувь нийлүүлсэн хөрөнгийг эзэмшдэг бол зохицуулалттай этгээдэд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.9.1. ажиллах боловсон хүчний 70-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэдээс бүрдсэн байх.

2.1.10. зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, үндсэн үйл ажиллагааг эрхлэх мэргэжилтнүүд хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

2.1.11. зохицуулалттай этгээдийн салбарт брокерийн үүрэг гүйцэтгэх ажилтан нь харилцагчдын мөнгөн хөрөнгийг хүлээн авах, дамжуулах үйлчилгээ үзүүлдэггүй, зөвхөн харилцагчдын захиалга, бусад холбогдох баримтыг хүлээн авч бүрдүүлэн түүнийгээ төвдөө дамжуулах, харилцагчдад эргэж мэдэгдэх, харилцагчийн бүртгэл хөтлөх зэрэг ажил эрхэлдэг бол уг брокерийн ажлыг анхан шатны зуучлагчаар дамжуулан гүйцэтгэж болох бөгөөд уг зуучлагч нь Хорооноос зөвшөөрсөн анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай. Холбогдох хууль тогтоомжоор хориглоогүй бол уг ажилтан нь анхан шатны зуучлалын үйлчилгээг үндсэн ажилтайгаа хавсран эрхэлж болно.

2.1.12. Энэ журмын 2.1.5-д заасан шалгуурыг тодорхойлохдоо дараах мэдээллийг үндэслэнэ:

2.1.12.1. тухайн этгээдээс ирүүлсэн өргөдөл, холбогдох бичиг баримт;  
2.1.12.2. татварын өргүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт;  
2.1.12.3. ял шийтгэлгүй талаарх тодорхойлолт;  
2.1.12.4. хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт;  
2.1.12.5. гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүдийн өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

2.1.12.8. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл.

2.1.13. гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээд тухайн орны онцлогоос шалтгаалан энэ журмын 2.1.5.1, 2.1.5.2, 2.1.5.3-д заасан тодорхойлолтуудыг гаргаж ирүүлэх боломжгүй бол гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн үүсгэн байгуулагч нараас энэ тухай тодорхойлолтыг ирүүлнэ;

2.1.14. гадаадын хөрөнгө оруулалттай зохицуулалттай этгээдийн хөрөнгө оруулагч нь гадаадын хуулийн этгээд бол тухайн орныхоо эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар, гадаадын иргэн бол овог нэр, хаяг байршил бүхий бичиг баримт, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг. Хороо шаардлагатай гэж үзвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 64.4-д заасны дагуу тухайн орны холбогдох байгууллагуудаас лавлагаа хүсэж болно.

2.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47, 49-т заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.2.1. үнэт цаасны арилжаа эрхлэх нэгжтэй байх;

2.2.2. дотоод мэдээлэл болон нийтэд зориулсан мэдээллийн үйл ажиллагааг хариуцан ажиллах бие даасан нэгжтэй байх;

2.2.3. шинээр гаргах үнэт цаасыг бүртгэх болон бүртгэлээс хасах үйл ажиллагаа эрхлэх бие даасан нэгжтэй байх;

2.2.4. үнэт цаасны арилжааг хянах бие даасан нэгжтэй байх;

2.2.5. эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх;

2.2.6. үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч байгаа хуулийн этгээд нь үнэт цаасны арилжааны төлбөрийн болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд холбогдсон байх.

2.3. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэх болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.3.1. үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай програм хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

2.3.2. үнэт цаасны тооцооны үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;

2.3.3 эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх;

2.3.4. үнэт цаасны арилжааны тооцооны эсхүл кастодианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь Хөрөнгийн биржийн арилжааны цахим сүлжээнд холбогдсон байх.

2.4. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан чиг үүргийг гүйцэтгэх болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.4.1. үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай програм хангамж, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

2.4.2. үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;

2.4.3. эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх;



2.4.4. үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээд нь Хөрөнгийн биржийн арилжааны цахим сүлжээнд холбогдсон байх.

2.5. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42, 45-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах шаардлага, нөхцлийг хангасан байна:

2.5.1. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;

2.5.2. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэх бие даасан нэгжтэй байх;

2.5.3. дотоод мэдээлэл эзэмшигчдийн болон байгууллагын дотоод үйл ажиллагааг хянах, харилцагчдаас ирсэн санал гомдлыг шийдвэрлэх 2-оос доошгүй хяналтын ажилтантай байх;

2.5.5. эргэлтийн хөрөнгө нь нийт хөрөнгийн 30 хувиас багагүй байх.

2.6. Брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.6.1. Брокерийн тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон холбогдох бичиг баримтыг Хороонд ирүүлнэ.

2.6.2. брокерийн үйл ажиллагаа эрхлэх 2-оос доошгүй ажилтантай байх;

2.7. Дилерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.7.1. дилерийн тусгай зөвшөөрөл шинээр хүссэн хуулийн этгээд нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл болон холбогдох бичиг баримтыг Хороонд ирүүлнэ.

2.7.2. дилерийн үйл ажиллагаа эрхлэх орон тооны ажилтантай байх;

2.8. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28-д заасан болон энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.8.1. үнэлгээ, төсөл, судалгааны 3-аас доошгүй ажилтантай, тэдгээр нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос эрхлэх ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан бөгөөд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, дотоод хяналтын үйл ажиллагааг хавсран эрхэлдэггүй байх;

2.8.2. үнэт цаас гаргагчтай дараах зүйлийг тусгасан андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулна:

2.8.2.1. гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа;

2.8.2.2. андеррайтер болон үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг;

2.8.2.3. нийт үнэт цаас танилцуулагдсаны дараа тухай үнэт цааснаас андеррайтер захиалах хугацаа;

2.8.2.4. андеррайтерт төлөх шимтгэлийн хэмжээ;

2.8.2.5. андеррайтер хийх үүргээ биелүүлэхэд андеррайтертэй хийсэн тохиролцоо.

2.9. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана:

2.9.1. зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүрээнд харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар зөвлөгөө өгөхдөө тухайн зөвлөгөөнд холбогдох статистик тоо баримт, судалгаа шинжилгээний бүхий л материалыг үйлчлүүлэгчид гаргаж өгөх,

2.9.2. харилцагчид өгөх зөвлөгөөг боловсруулахдаа тоо баримт, зах зээлийн бодит байдалд тулгуурлан боловсруулах бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу тухайн баримт, зах зээлийн байдалд дүн шинжилгээ хийсэн байх,

2.9.3. зөвлөх үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд буюу тухайн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын зөвлөх ажилтан нь гэрээний дагуу харилцагчид зөвлөгөө өгөх бүхий л явцад зөвлөх үйлчилгээний хүрээнд харилцагчид санал болгож буй үнэт цаасны өмчлөгч буюу тухайн үнэт цаасыг гаргагчтай ашиг сонирхолын зөрчил үүссэн тохиолдолд энэ тухайгаа харилцагчид нэн даруй мэдэгдэх,

2.9.4. энэ журмын 2.8.2-д заасан ашиг сонирхолын зөрчил нь зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах үед үүсвэл тухайн гэрээ байгуулахаас өмнө харилцагчид мэдэгдэх,

2.9.5. харилцагчтай гэрээ байгуулахаас өмнө өөрийн санхүүгийн нөхцөл байдал болон өөрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх ажилтан нь сүүлийн 5 жилийн хугацаанд Хорооноос болон хууль хяналтын байгууллагаас өөрийн үүрэгт ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор захиргааны болон эрүүгийн шийтгэлээр шийтгүүлсэн эсэх тухай мэдээлийг харилцагчид гаргаж өгөх,

2.9.6. харилцагчийн санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын туршлага, хөрөнгө оруулалтын объектийн талаар судалгаа хийсний үндсэн дээр харилцагчийн дээрх нөхцөл байдалд хамгийн сайн нийцсэн зөвлөгөө өгөх,

2.9.7. харилцагчид өгөх зөвлөгөөг бие даасан, хараат бус байдлаар боловсруулах,

2.9.8. харилцагчид зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд гарч болох эрсдлийг тодорхойлж түүнээс сэргийлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий ажилтанууд холбогдох хууль тогтоомжийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж байгаа байдалд дүн шинжилгээ хийх, хянан шалгах тогтолцоог бүрдүүлсэн дотоод хяналтын журам баталж, мөрдүүлэх,

2.9.9. энэ журмын 2.9.8-д заасан журмын хэрэгжилтын талаар Хороонд жил тутам тайлагнах,

2.10. Брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн компани нь өөрийн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах сан байгуулж, сангийн хөрөнгийг өөрийн тусгайлсан дансанд тогтмол байршуулна. Уг сангийн харилцааг “Зохицуулалттай этгээдийн эрсдлийн сангийн тухай журам”-аар зохицуулна.

## **Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай бүрдүүлэх бичиг баримт**

3.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2-т зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.1.1. энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

3.1.2. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар баталгаажсан хуулбар;

3.1.3. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчилсэн хуулбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын газраас олгосон гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.4. улсын бүртгэлд бүртгүүлсэн Компанийн дүрэм. Тус дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна:

3.1.4.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;

3.1.4.2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;

3.1.4.3. хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн эрх, үүрэг, хариуцлага;

3.1.4.4. зохицуулалттай этгээдийн хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт;

3.1.4.5. зохицуулалттай этгээд татан буугдах үндэслэл, удирдлага, мэргэжилтнүүдийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.

3.1.4.6. дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

3.1.5. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт;

3.1.6. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө, эрсдлийн сангийн хөрөнгийг тус тус өөрийн харилцах банкинд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа;

3.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний тухай хуулийг хэрэгжүүлэх журмын төсөл;

3.1.8. аудитын байгууллагаар баталгаажсан сүүлийн улирлын санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс;

3.1.9. энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, бусад эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт,

3.1.10. гүйцэтгэх удирдлага болон мэргэжилтнүүд нь энэ журмын 2.1.3-д заасан эрхийн үнэмлэхийн хуулбар, энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу тэдгээрийн тухай тодорхойлолт;

3.1.11. хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүд энэ журмын 14 дүгээр зүйлд заасан тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

3.1.12. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан бол тухайн хуулийн этгээдийн хувьцааны арилжааны сүүлийн нэг жилийн арилжааны тайлан;

3.1.13. ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар баталгаажсан хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.14. энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу боловсруулсан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх гурваас доошгүй жилийн бизнесийн болон эрсдлийн удирдлагын төлөвлөгөө;

3.1.15. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга. Зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд зохицуулалттай үйл ажиллагаа тус бүрийг дотооддоо удирдан зохион байгуулах нэгжийн талаарх танилцуулга;

3.1.16. үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт, энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан ажлын байрны тодорхойлолт;

3.1.17. энэ журмын 2.1.6-д заасан зохицуулалттай үйл ажиллагаанд үүсч болзошгүй ашиг сонирхолын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам;

3.1.18. банк, түүний толгой, хараат болон охин компани, банкны нэгдэлд орсон болон банкны хувьцааны таваас дээш хувийг эзэмшиж буй аливаа хуулийн этгээд нь зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй талаарх Монголбанкны ерөнхийлөгчийн дүгнэлт;

3.1.19. Брокер, дилер, андеррайтерийн компани нь өөрийн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх эрсдлээс хамгаалах сангийн мөнгөн хөрөнгийг өөрийн тусгайлсан дансанд байршуулсан банкны тодорхойлолт.

3.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 21.2.2, энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг ирүүлнэ:

3.2.1. үндсэн үйл ажиллагаанд ашиглах програмын танилцуулга, үнэт цаасыг бүртгэх болон арилжааны журам;

3.2.2. үнэт цаасны арилжаа зохион байгуулах журам;

3.2.3. үнэт цаасыг бүртгэх, бүртгэлээс хасах асуудлыг хариуцах бие даасан нэгжийн үйл ажиллагааны тухай журам;

3.2.4. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу дотооддоо гаргасан журам, зааврууд;

3.2.5. арилжаа эрхлэх байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэр, тэдгээрийн эрхэлж буй албан тушаал болон эзэмшиж буй үнэт цаасны талаарх тодорхойлолт;

3.2.6. арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг бүрдүүлсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хөрөнгийн хувь хэмжээ. Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлагуудын хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцохгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй байх талаарх баталгаа;

3.2.7. үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл;

3.2.8. үнэт цаасны арилжаа эрхлэх хуулийн этгээдийн гишүүнтэй байгуулах гэрээний төсөл;

3.2.9. техник, тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны тодорхойлолтыг энэ журмын хавсралтын дагуу үйлдэж, түүнд техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгай, дурдсан шаардлагын талаар бусад этгээдтэй байгуулсан гэрээ буюу нотариатын байгууллагаар баталгаажуулсан гэрээний хуулбар;

3.2.10. энэ журмын 3.2.1-3.2.9-д заасан бичиг баримтад өөрчлөлт орсон тухай бүр холбогдох бичиг баримтыг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

3.3. Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.3.1. хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны төлбөр, тооцоотой холбоотой болзошгүй эрсдлээс хамгаалах сан байгуулах, байршуулах ба тухайн сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журам;

3.3.2. үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагааны журам;

3.3.3. үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

3.3.4. үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан төлбөр, тооцооны үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл;

3.3.5. үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд төлбөр, тооцооны үйл ажиллагааг бие даан эрхлэх дотоод нэгжийн үйл ажиллагааны журам;

3.3.6. үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн дүнд үүссэн тооцоог тодорхойлох, төлбөрийг хийж гүйцэтгэх журам, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам;

3.3.7. Энэ журмын 3.3.1-3.3.6-д заасан бичиг баримтад өөрчлөлт орсон тухай бүр холбогдох бичиг баримтыг ажлын 10 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

3.4. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.4.1. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг эрхлэх нэгжийн чиг үүргийг онцгойлон заасан үйл ажиллагааны журам;

3.4.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд;

3.4.3. харилцагчдын хөрөнгийг эрсдлээс хамгаалах зорилгоор даатгалын байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

3.4.4. харилцагчидтай байгуулах хадгаламжийн гэрээний төсөл;

3.4.5. харилцагчийн үнэт цаас худалдсаны болон ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг байршуулан хадгалах арилжааны банкттай байгуулах гэрээний төсөл;

3.4.6. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх журам. Тус журамд дараах зүйлүүдийг заавал тусгасан байна:

3.4.6.1. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл явуулахад үндэслэх бичиг баримт, мэдээлэл;

3.4.6.2. харилцагчийн дансны хуулга, түүний хэлбэр, агуулга, хугацаа;

3.4.6.3. үнэт цаасыг харилцагчийн дансанд бүртгэх, үнэт цаасын өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэсэн бичиг баримтыг хадгалах заавар;

3.4.6.4. харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ;

3.4.6.5. үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэл, шилжүүлэг, мэдээллийн сангийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам.

3.4.6.6. үнэт цаас гаргагчтай үнэт цаасны бүртгэлийг хөтлөх талаар байгуулах гэрээний төсөл;

3.4.6.7. Энэ журмын 3.4.6.1-3.4.6.7-д заасан бичиг баримтад өөрчлөлт орсон тухай бүр холбогдох бичиг баримтыг Хороонд ирүүлнэ.

3.5. Брокерийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.5.1. брокерийн үйл ажиллагааны чиглэлээр дараах журмуудын эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хувь:

3.5.1.1. брокерийн үйл ажиллагааны журам;

3.5.1.2. дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам;

3.5.1.3. харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагааны тухай журам;

3.5.1.4. харилцагчид, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай журам.

3.5.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн брокерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт.

3.6. Дилерийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.6.1. дилерийн үйл ажиллагааны чиглэлээр дараах журмуудын эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хувь:

3.6.1.1. дилерийн үйл ажиллагааны журам;

3.6.1.2. дотоод хяналтын үйл ажиллагааны тухай журам.

3.6.2. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тухайн дилерийн компанийг шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх гаргасан дүгнэлт.

3.7. Андеррайтерийн компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

3.7.1. андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам. Тус журамд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4-д зааснаас гадна дараах төрлүүдийн аль хэлбэрээр үнэт цаас гаргагчтай ажиллахыг тодорхой тусгана:

3.7.1.1. хоёрдогч зах зээлд худалдах буюу өөрийн үнэт цаасны багцад хадгалах зорилготойгоор анхдагч зах зээлд үнэт цаас гаргагчийн гаргасан үнэт цаасыг бүхэлд нь худалдан авах /firm commitment/;

3.7.1.2. үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасны зарим хэсгийг худалдан авах /standby commitment/;

3.7.1.3. Гаргасан үнэт цаасыг худалдан авахгүйгээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах /best effort/;

3.7.1.4. Гаргасан үнэт цаас нь анхдагч зах зээлд арилжигдах боломжгүй нөхцөлд үнэт цаасыг нь тогтоосон үнээр худалдан авах баталгаа гаргах /bought deal/.

3.8. Хөрөнгө оруулалтын зөвлөх компани нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

3.8.1. хөрөнгө оруулалтын зөвлөх компани болон үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний хооронд байгуулсан гэрээний нотариатаар баталгаажуулсан хувь;

3.8.2. үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхөөр ажиллах мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм;

3.8.3. үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх мэргэжилтний үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ үзүүлэх эрхийн үнэмлэхний хуулбар, мэргэшсэн байдлын тухай танилцуулга, нотлох баримт;

3.8.4. мэргэжилтний үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр гадаадын болон дотоодын сургалтад хамрагдаж мэргэшсэн тухай үнэмлэх, сертификат, дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар.

3.9. гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл хүсэхдээ энэ журмын холбогдох заалтуудад заасан бичиг баримтуудыг Монгол хэл дээр үйлдэж ирүүлнэ.

3.10. тусгай зөвшөөрөл хүсч буй байгууллага нь ирүүлсэн бичиг баримтдаа нэмэлт өөрчлөлт оруулсан бол энэ тухайгаа ажлын 15 хоногийн дотор Хороонд мэдэгдэнэ.

#### **Дөрөв. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бичиг баримтыг хянах**

4.1. Хороо тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг 30 хоногт багтаан хянаж шийдвэрлэнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

4.3. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү журмын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт холбогдох бичиг баримтыг дараах байдлаар хянана:

4.3.1. үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нарын хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчийн хууль ёсны орлого, эх үүсвэрээс бүрдсэн эсэх;

4.3.2. хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг хангасан эсэх;

4.3.3. зохицуулалттай этгээдийн гурван жилийн бизнес төлөвлөгөөнд Монголын үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдал, үйлчилгээний онцлог, харилцагч, хөрөнгө оруулагчийг татах, гадаад дотоод хүчин зүйлсийг харгалзан үйл ажиллагааны бодит төлөвлөгөө боловсруулан судалгаа хийсэн эсэхэд дүгнэлт гаргах;

4.3.4. компанийн дүрэм, тухайн тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааны журам, дотоод хяналтын журам, харилцагчид хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх болон харилцагчдийг эрсдэлээс хамгаалах журам, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Хорооноос баталсан холбогдох журам, зааварт нийцэж буй эсэх;

4.3.5. тусгай зөвшөөрөл хүсэгч этгээд тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд түүний бусад үйл ажиллагаатай харшлах эсэх, сонирхолын зөрчил үүсэх эсэх;

4.3.6. үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, мэргэжилтнүүд нь журамд заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж буй эсэх;

4.3.7. брокер, дилерийн компанийн хувьд дотоод ажиллагааны горим, хяналтын зохих тогтолцоотой эсэх, Арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн нөхцөл, шаардлагыг хангасан талаарх дүгнэлт ирүүлсэн эсэх;

4.3.8. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн үйл ажиллагааг эрхлэх шаардлагыг хангасан эсэх;

4.4. Хороо шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтын талаар холбогдох газраас тодруулах, магадлан шинжлүүлэх, лавлагаа авах эрхтэй.

4.5. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл холбогдох бичиг баримтын бүрдэл дутуу, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангаагүй бол тухайн компанид албан бичгээр мэдэгдэж нэмэлт бичиг баримтыг шаардаж болно.

4.6. Тусгай зөвшөөрөл хүсч буй хуулийн этгээдээс ирүүлсэн бичиг баримтыг дараах тохиолдолд ажлын 10 хоногийн дотор тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд буцаана:

4.6.1. бичиг баримтын бүрдэл дутуу;

4.6.2. тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримт нь холбогдох хууль болон энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаагүй;

4.6.3. энэ журмын **4.3.3-т** заасан дүгнэлтээр зохицуулалттай этгээдийн бизнес төлөвлөгөө шаардлага хангаагүй;

4.6.4. тусгай зөвшөөрлийн бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон.

4.7. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг буцаах тохиолдолд үндэслэл бүхий тайлбарын хамт өргөдөл гаргагчид Ажлын албанаас албан бичгээр мэдэгдэнэ.

4.8. Энэ журмын 4.6.4-д заасан үндэслэлээр Хороо бичиг баримтыг буцаасан тохиолдолд буцаасан өдрөөс хойш 1 жилийн дотор уг хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагад ажиллаж байсан этгээдүүдээс тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

4.9. Энэ журмын **4.6.4-д** зааснаас бусад үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагуудыг бүрэн хангасан гэж үзсэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Хороонд дахин гаргаж болно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дахин төлнө.

4.10. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

### **Тав. Тусгай зөвшөөрөл олгох**

5.1. Өргөдөл гаргагч нь дараахь нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд Хороо тусгай зөвшөөрөл олгоно:

5.1.1. хуулийн этгээд тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд түүний бусад үйл ажиллагаатай харшлахгүй, сонирхлын зөрчил үүсгэхгүй гэж үзсэн;

5.1.2. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд болох нь тогтоогдсон;

5.1.3. хүний нөөцийн хувьд Хорооноос тогтоосон шаардлага хангасан;

5.1.4. хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн болон эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг хангасан;

5.1.5. ажлын байр, техник, програм хангамж нь тухайн үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангасан;

5.1.6. хорооноос тогтоосон бусад нэмэлт нөхцөл, шаардлагыг хангасан.

5.2. Тусгай зөвшөөрөл бүхий тухайн үйл ажиллагааг эрхлэх нөхцөл, шаардлагыг хангаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.3. Үнэт цаасны газрын даргын томилсон ажлын хэсэг тусгай зөвшөөрөл хүсч буй этгээдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, програм хангамж нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргасан байна.

5.4. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэ журмын дагуу хянаж, Ажлын албанаас санал, дүгнэлт боловсруулан Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.5. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн зохицуулалттай этгээдэд үнэт цаасны зах зээлд ямар төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана.

5.6. Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг зохицуулалттай этгээдийн холбогдох удирдлагад албан бичгээр мэдэгдэнэ.

5.7. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг ажлын 3 хоногт багтаан Хорооны дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоног байршуулах бөгөөд мөнгөн хөрөнгөд Хороо хүү төлөхгүй.

5.8. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн байгууллагын албан ёсны хүсэлт, нэхэмжлэлийг үндэслэн тухайн зохицуулалттай этгээдийн харилцах дансанд буцаан шилжүүлнэ.

5.9. Хорооны шийдвэр болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, хувь нийлүүлсэн хөрөнгийг Хорооны дансанд төвлөрүүлсэн баримтыг тус тус үндэслэн тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг, хавсралтын хамт олгож, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

### **Зургаа. Тусгай зөвшөөрлийг сунгах**

6.1. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй этгээд нь уг үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн эрхлэхийг хүсвэл тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 60-аас доошгүй хоногийн өмнө Хороонд өргөдөл гаргахдаа энэхүү журмын дагуу бичиг баримтаа бүрдүүлж, хавсарган ирүүлнэ. Тусгай зөвшөөрлийн хугацаанд хүсэлт гаргаж өргөдөл ирүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах санал, дүгнэлтийг Ажлын албанаас Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.



6.2. Тусгай зөвшөөрөлийг сунгуулахыг хүсч буй зохицуулалттай этгээд нь дараах шаардлага нөхцлийг хангасан байна:

6.2.1. хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг сүүлийн 4 улирал дараалан хангаж ажилласан байх;

6.2.2. зохицуулалттай этгээдийн буруутай үйл ажиллагаанаас харилцагч, хөрөнгө оруулагчдад их хэмжээний хохирол учруулсан талаар Хороо, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагад бүртгэгдээгүй байх;

6.3. Тусгай зөвшөөрлийг сунгуулахдаа дараах бичиг баримтыг Хороонд бүрдүүлж ирүүлнэ:

6.3.1. тусгай зөвшөөрлийг сунгуулах тухай өргөдөл;

6.3.2. зохицуулалт үйлчилгээний хураамж төлсөн баримт;

6.3.3. хэрэв зохицуулалттай этгээд орон нутагт салбартай бол үйл ажиллагааны тайлан мэдээлэл;

6.3.4. зохицуулалттай этгээд гурван жилийн бизнес төлөвлөгөөгөө хэрхэн хангаж ажилласан талаарх дэлгэрэнгүй тайлан;

6.3.5. энэхүү журмын **3.1.2-3.1.5, 3.1.9-3.1.16, 3.3.7, 3.8**-д заасан бичиг баримтыг эрхэлж буй зохицуулалттай үйл ажиллагааны чиглэлтэй холбогдуулан бүрдүүлж ирүүлнэ.

**6.3.6. арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажилласан талаарх мэдээлэл;**

6.4. Тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногт хянаж, Ажлын алба Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

6.5. Хэрэв зохицуулалттай этгээдэд нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал, дүгнэлтийг Ажлын албанаас Хорооны хуралдаанд танилцуулж хэлэлцүүлнэ.

6.6. Хуралдаанаас гарсан шийдвэрийг албан бичгээр зохицуулалттай этгээдэд ажлын гурван хоногийн дотор мэдэгдэнэ.

6.7. Хорооноос гаргасан шийдвэр болон тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгалтыг тэмдэглэж, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

6.8. Зохицуулалттай этгээдэд тусгай зөвшөөрлөө сунгуулах хүсэлт, холбогдох бичиг баримтаа тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ирүүлээгүй тохиолдолд Хорооны хянан шалгагч тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан өдрөөс эхлэн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг түр зогсоож, Ажлын албанаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах асуудлыг Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

### **Долоо. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгох**

7.1. Үнэт цаасны зах зээлд энэхүү журмын **1.4**-д заасан зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах шалгууруудыг хангасан зохицуулалттай этгээдэд нэмж олгоно:

7.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмуудад заасан шаардлагыг бүрэн хангасан;

7.1.2. хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн дөрвөн улирал дараалан хангаж ажилласан байх;

7.1.3. тухайн байгууллагын санхүү, төлбөрийн чадвар болон хувьцаа эзэмшигчийн ёс зүй нь уг үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй байх.

7.2. Зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд нэмж эрхлэх үйл ажиллагааг тусгаж, дараах бичиг баримтуудын хамт Хороонд ирүүлнэ:

7.2.1. тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх талаарх хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, нэмж шаардагдах хувь нийлүүлсэн хөрөнгө, зардал, тэдгээрийн эх үүсвэрийн тооцоо, гурван жилийн бизнес болон эрсдлийн төлөвлөгөө;

7.2.2. зохицуулалттай этгээдийн дүрэмд орох өөрчлөлт, дүрмийн төсөл;

7.2.3. тухайн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд мөрдөх журам. Тус журамд хавсран эрхлэх зохицуулалттай үйл ажиллагааны нэр төрөл, зохицуулалт, оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, үйл ажиллагааны эрсдэлийг тооцох аргачлал, харилцагчдын хохирлыг барагдуулах зохицуулалтыг зэргийг тодорхой тусгасан байна.

7.2.4. Зохицуулалттай этгээд нь брокер болон дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж хүссэн тохиолдолд энэ журмын 3.5.2, 3.6.2-т заасан тодорхойлолт.

7.3. Ажлын албанаас зохицуулалттай үйл ажиллагаа хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн бичиг баримтыг хянан шалгаад, энэ нь тухайн байгууллагын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй, харилцагчдад нь аливаа хохирол учруулахгүй, боловсон хүчний болон техник, тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд эрхлэх нөхцлийг хангаж байна гэж үзвэл уг тусгай зөвшөөрлийг олгох шийдвэрийг Хороо гаргана.

7.4. Хорооны шийдвэр гарсны дараа хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг Ажлын албанаас албан бичгээр мэдэгдэнэ.

7.5. Хувьцаа эзэмшигч нар нь тус албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд хуанлийн 10 хоногийн хугацаагаар байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

7.6. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг 10 хоногт Хорооны дансанд төвлөрүүлсэн талаарх баримт, зохицуулалт үйлчилгээний хөлс төлсөн баримтыг тус тус үндэслэн Хороо тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

7.7. Хороо энэ журмын 7.3-д заасан нөхцлийг хангаагүй гэж үзвэл тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзаж, албан бичгээр мэдэгдэнэ.

7.8. Тодорхой шалтгаанаар зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос Хороо татгалзснаас хойш хүсэлт гаргасан зохицуулалттай этгээд татгалзсан шалтгааныг арилгасан гэж үзээд зохицуулалттай үйл ажиллагааны хавсран эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтээ Хороонд дахин гаргаж болно. Энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дахин төлнө.

### **Найм. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох, бүртгэх**

8.1. Зохицуулалттай этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно:

8.1.1. хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөр;

8.1.2. хувьцаа эзэмшигчдийн үндсэн үйл ажиллагаа эрхлэх явцад бий болсон хуримтлагдсан ашгаар нэмж хөрөнгө оруулах;

8.1.3. хувьцаа нэмж гаргах, шинээр хувьцаа эзэмшигч элсүүлэх хэлбэрээр.

8.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөл авахдаа эдгээр өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө дараах бичиг баримтуудыг Хороонд бүрдүүлж ирүүлнэ:

8.2.1. өргөдөл (өөрчлөлт оруулах болсон үндэслэл тайлбарыг тусгасан байх);

8.2.2. өөрчлөлт оруулах болсон хууль зүйн үндэслэлийг нотлох баримт;

8.2.3. зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хувь нийлүүлэн шинээр орж буй хувьцаа эзэмшигчийн хувьд энэ журмын 2.1.7-д заасан тохиромжтой этгээдийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг ирүүлэх;

8.2.4. шинээр хувьцаа эзэмшигчээр орж буй этгээдийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах хөрөнгө нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох бичиг баримт;

8.2.5. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний тухай хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

8.2.6. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийг өөрчлөхтэй холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн төсөл;

8.2.7. зохицуулалтын үйлчилгээний хураамж төлсөн баримт.

8.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохыг хүсч зохицуулалттай этгээдээс ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг Хорооны Ажлын алба холбогдох хууль журмын заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах эсэх талаар шийдвэр гаргана.

8.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах нь зохицуулалттай этгээдийн санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй гэж үзвэл Ажлын алба санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга хувь нийлүүлсэн хөрөнгийг хорогдуулах зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргана.

8.5. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох эсэхийг ажлын 14 хоногийн дотор шийдвэрлэнэ. Энэ журмын 8.2-д заасан бичиг баримт нь зохих шаардлага хангасан гэж үзвэл хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд байршуулахыг албан бичгээр мэдэгдэнэ.

8.6. Хувьцаа эзэмшигч нар нь тус албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооны дансанд хуанлийн 10 хоногийн хугацаагаар байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

8.7. Зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хуанлийн 10 хоногийн хугацаанд Хорооны дансанд төвлөрүүлсэн баримт, зохицуулалт үйлчилгээний хөлс төлсөн баримтыг тус тус үндэслэн Хороо тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

## **Ес. Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх**

9.1. Зохицуулалттай этгээд нь оноосон нэрээ өөрчлөх тохиолдолд Хороонд дараах бичиг баримтуудыг ирүүлнэ:

9.1.1. өргөдөл (оноосон нэр өөрчлөх болсон үндэслэл, тайлбарыг тусгасан байх);

9.1.2. зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

9.1.3. улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн тодорхойлолт;

9.1.4. өөрчлөлт оруулсан дүрмийн төсөл;

9.1.5. зохицуулалтыг үйлчилгээний хөлс төлсөн баримт.

9.2. Оноосон нэр өөрчлөх тухай хүсэлтийг холбогдох бичиг баримт бүрэн гүйцэд бүрдсэнээс хойш ажлын 10 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

9.3. Ажлын алба зохицуулалттай этгээдийн оноосон нэр солих хүсэлтийг хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь зохицуулалттай этгээдийн харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

9.4. Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай Хорооны даргын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, шинээр олгож, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

### **Арав. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх**

10.1. Зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлаа шинээр томилох, өөрчлөх асуудлыг Хорооны дарга шийдвэрлэнэ.

10.2. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож буй этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

10.2.1. дээд боловсрол эзэмшсэн байх;

10.2.2. удирдах ажлын туршлагатай байх;

10.2.3. энэ журмын 2.1.5-д заасан шалгуурыг хангасан байх.

10.3. Хорооноос зөвшөөрөл авахдаа дор дурьдсан бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:

10.3.1. гүйцэтгэх захирлаар томилох этгээдийн товч намтар, анкет,

10.3.2. төгссөн сургуулийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

10.3.3. өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

10.3.4. үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхийн хуулбар;

10.3.5. гүйцэтгэх захирлаар томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

10.3.6. энэ журмын 2.1.7-д заасан тодорхойлолтууд.

10.4. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь зохицуулалттай этгээдийг удирдах мэдлэг боловсрол, ёс зүй, дадлага туршлага, тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангасан гэж үзвэл гүйцэтгэх захирлаар томилохыг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

10.5. Журмын 10.4 дэх хэсгийг үндэслэн Ажлын алба тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж зохих бүртгэлд бүртгэнэ.

10.6. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь энэ журмын 10.2-т заасан шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр зөвшөөрөл өгөхөөс татгалзсан тохиолдолд тухайн зохицуулалттай этгээд гүйцэтгэх захирлыг томилох зөвшөөрөл авахаар өөр этгээдийг нэг сарын дотор санал болгож болно.

### **Арван нэг. Зохицуулалттай этгээдийн салбар байгуулах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох**

11.1. Хорооны дарга зохицуулалттай этгээдийн салбар нээх зөвшөөрлийг олгоно.

11.2. Зохицуулалттай этгээдийн салбар нь зөвхөн тухайн зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг хэрэглэх бөгөөд салбарын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хүрээ, ажиллах журмыг зохицуулалттай этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно.

11.3. Зохицуулалттай этгээд нь зөвшөөрөлгүйгээр салбарын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

11.4. Гадаадын үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр салбар, төлөөлөгчийн газраа нээх тохиолдолд Хорооноос зөвшөөрөл авна.

11.5. Салбар байгуулах зохицуулалттай этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

11.5.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан;

11.5.2. сүүлийн дөрвөн улиралд Хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан;

11.5.3. салбар нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалт, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах эрх авсан орон тооны салбарын эрхлэгч, мэргэжилтэнтэй байх.

11.6. зохицуулалттай этгээд нь салбар нээх зөвшөөрөл хүсэхдээ дараах бичиг баримтыг Хороонд ирүүлнэ:

11.6.1. салбар нээх тухай хүсэлт;

11.6.2. төлөөлөн удирдах зөвлөл, байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр;

11.6.3. салбарын гүйцэтгэх удирдлага, мэргэжилтний тодорхойлолт, Хорооноос олгосон эрхийн үнэмлэх, иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, энэхүү журмын 2.1.7-д заасан тодорхойлолтууд;

11.6.4. салбарын дотоод хяналтыг хэрэгжүүлэх болон салбарын үйл ажиллагааг зохицуулах журам;

11.6.5. салбарын үйл ажиллагаа явуулах ажлын байр, үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмж, програм хангамжийн талаарх танилцуулга;

11.6.6. Хорооноос шаардсан бусад бичиг баримт.

11.7. Ажлын алба энэ журмын 11.6-д заасны дагуу ирүүлсэн бичиг баримтыг хянан үзэж, салбар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхөөргүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулаагүй, боловсон хүчин, тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангасан гэж үзвэл Хорооны дарга зөвшөөрөл олгоно.

11.8. Зохицуулалттай этгээд нь салбараа нээх, татан буулгах, үйл ажиллагаагаа хязгаарлах, өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/, байршлыг нь өөрчлөх тухай бүрд

шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Хороонд мэдэгдэж бүртгүүлнэ.

11.9. Зохицуулалттай этгээдийн салбар нээх тухай Хорооны даргын шийдвэр, тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоох тухай журамд зааснаар зохих хураамжийг Хорооны дансанд төлсөн баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтанд салбарын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулна.

11.10. Хорооны дарга тухайн зохицуулалттай этгээдийн салбар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооны Ажлын албанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл салбарын үйл ажиллагааг зогсооно.

11.11. Зохицуулалттай этгээдийн салбарын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ:

11.11.1. салбар татан буулгах тухай зохицуулалттай этгээдийн шийдвэр;

11.11.2. тухайн салбарын үйл ажиллагаа нь зохицуулалттай этгээдийн хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосон Хорооны улсын байцаагчийн дүгнэлт;

11.11.3. Хорооноос салбарын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд тухайн орон нутагт үйл ажиллагаа эрхлээгүй;

11.11.4. салбарын үйл ажиллагааг 3-аас дээш сарын хугацаагаар зогсоосон;

11.11.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

11.12. Зохицуулалттай этгээд салбарын үйл ажиллагааг зогсоох үндэслэл болсон зөрчлийг арилгаж, зохих шаардлагыг хангасны дараа салбар нээх хүсэлтийг дахин хүлээж авах бөгөөд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хүсэлт гаргах бүрдээ журамд заасан хэмжээгээр төлнө.

11.13. Орон нутагт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд нь Улаанбаатар хотод салбар нээх тохиолдолд журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

### **Арван хоёр. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

12.1. Хороо тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-т зааснаас гадна дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

12.1.1. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд явуулаагүй;

12.1.2. хууль зөрчиж, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон;

12.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон;

12.1.4. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр дараалан хангаж ажиллаагүй;

12.1.5. хагас болон жилийн санхүүгийн тайлан тэнцлийг холбогдох тодруулгын хамт ирүүлээгүй;

12.1.6. Хорооноос мэдээллийн сангийн журмын дагуу шаардсан мэдээллийг удаа дараа хугацаанд нь гаргаж өгөөгүй болон алдаатай, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн;

12.1.7. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлс төлөх хугацааг 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

12.1.8. зохицуулалттай этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд биш болсон;

12.1.9. хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн, үнэт цаасны арилжаа эрхлэх болон үнэт цаасны хадгаламжийн байгууллага, мэргэжлийн холбоо зэрэг эрх бүхий өөрийгөө зохицуулагч байгууллагаас гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий бол;

12.1.10. журмын 1.7-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүй;

12.1.11. хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

12.1.12. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

12.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлнэ. Хорооноос тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрлийг сэргээх бөгөөд хэрэв тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд хүсэлт ирүүлээгүй тохиолдолд Ажлын алба тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар Хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

12.3. Хороо Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т зааснаас гадна дор дурьдсан тохиолдолд зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

12.3.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

12.3.2. зохицуулалттай этгээд дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон буюу татан буугдсан тухай эрх бүхий байгууллага болох шүүх, зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;

12.3.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа ноцтой зөрчсөн;

12.3.4. харилцагчдад их хэмжээний хохирол учруулсан;

12.3.5. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахад харшлах бусад нөхцөл байдал үүссэн;

12.3.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаж, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

12.3.7. тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан хэдий ч хүсэлтээ Хороонд ирүүлээгүй.

12.3.8. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон.

12.4. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд:

12.4.1. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн зохицуулалттай этгээдийн хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ;

12.4.2. тусгай зөвшөөрөл дахин олгохтой холбоотой хүсэлтийг тухайн байгууллагаас 1 жилийн дотор хүлээн авахгүй;

12.4.3. Хороо үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхээр олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

### **Арван гурав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар**

13.1. Хороо нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн болон хүчингүй болгосон шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор энэ тухай нийтэд мэдээлнэ.

13.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд харилцагчдыг шилжүүлэх ажиллагааг Хороо тогтоосон журмын хүрээнд хэрэгжүүлнэ.

13.3. Хороо шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн этгээдээс харилцагчийн дансанд нэвтрэх, гүйлгээ хийх эрхийг хязгаарлах, эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, тусгаарлах, арга хэмжээг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлж болно.

13.4. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хороо тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон хуулийн этгээдээс үйлчлүүлэгчийнхээ дансанд нэвтрэх, гүйлгээ хийх эрхийг хязгаарлах, түүний хөрөнгийг битүүмжлэх, эрхэлж байсан үйл ажиллагаатай нь холбоотой баримтыг хамгаалалтад авах, архивт шилжүүлэх арга хэмжээг авч болно.

13.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нь тухайн зохицуулалттай этгээдээс бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг дуусгавар болгох буюу уг гэрээ хэлцлээр хүлээсэн, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй бөгөөд харилцагчдад учирсан хохирлыг зохицуулалттай этгээд болон түүний эрх бүхий албан тушаалтан хариуцна.

13.6. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл бүхий бусад үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш ажлын 45 өдрийн дотор татан буугдах эсэх асуудлаа эрх барих байгууллагаараа хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

13.7. Энэ журмын 13.6-д заасан хугацаанд татан буугдах эсэхээ шийдвэрлээгүй хуулийн этгээдийг албадан татан буулгах шийдвэр гаргуулахаар Хороо шүүхэд нэхэмжлэл гаргана.

13.6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн өдрөөс хойш зохицуулалттай этгээд нь түдгэлзүүлсэн нөхцөл, шалтгааныг арилгахаас бусад дараах үйлдэл хийхийг хориглоно:

13.6.1. шинээр гэрээ байгуулах;

13.6.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

13.7. тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

13.7.1. брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд дараах бичиг баримтыг архивын журмын дагуу нэгж болгон цэгцэлж, хавтаслан өөрийн харъяалах арилжаа эрхлэх байгууллагын архивт хүлээлгэн өгнө:

13.7.1.1. үйл ажиллагаа явуулсан бүхий л хугацаанд харилцагчдаас хүлээн авсан үнэт цаас худалдах, худалдан авах захиалгын гэрээнүүд;

13.7.1.2. мөн хугацааны бүх захиалгын бүртгэлүүд;

13.7.1.3. мөн хугацааны бүх дилерийн даалгаварууд;

13.7.1.4. мөн хугацааны харилцагчдийн бүх бүртгэлүүд;

13.7.1.5. мөн хугацаанд харилцагчдад мөнгө олгосон бүртгэл, мөнгөн хөрөнгийн баримтууд, түүний дотор мөнгө хүссэн өргөдлүүд;

13.7.1.6. харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой бусад үндсэн баримтууд;

13.7.1.7. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт заасан бусад баримтууд.

13.8. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэрт ямар бичиг баримтыг ямар хугацаанд хаана хүлээлгэн өгөх талаар тодорхой заана.

13.9. Энэ журмын 13.7.1 болон Хорооны шийдвэрт заасан бичиг баримтыг зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас харилцагчдад учруулсан хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан компанийн хувьцаа эзэмшигч, хэрэв тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ХК бол тухайн үеийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан эрх бүхий этгээдүүд хариуцаж барагдуулна.

**Арван дөрөв. Тохиромжтой этгээдийг тодорхойлох**



14.1. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.1-д заасан шалгуурыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ:

14.2. Энэ журмын 14.1-д заасан шалгуурыг дараах байдлаар ойлгоно:

14.2.1. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх,

14.2.2. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг ижил төстэй байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх,

14.2.3. Санхүүгийн зохицуулах хороо болон түүний Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, Хорооны Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан биш байх,

14.2.4. энэ журмын 2.1.5.3-т заасан шалгуурыг хангасан байх,

14.3. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурыг тодорхойлохдоо шаардлагатай нотлох баримтыг үндэслэнэ. Монгол Улсын болон гадаад улсын Засгийн газрын агентлаг, мэргэжлийн байгууллага, зохицуулалтын бусад байгууллага, хууль хяналтын байгууллагаас мэдээлэл лавлагаа авч болно.

14.4. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эрхлэх, эсхүл эрх бүхий албан тушаалтнаар томилогдох хүсэлт гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан нь өөрийн тохиромжтой этгээд болохоо нотлох баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлэх үүрэгтэй.

14.5. Энэ журамд заасны дагуу тохиромжтой этгээдийн шаардлага хангасан баримт нотолгоо бүрэн, хангалттай гэж үзвэл хүсэлтийг ажлын 20 хоногт багтаан шийдвэрлэнэ.

14.6. Үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь энэ журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг байнга хангаж ажиллана. Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд улсын байцаагч, хянан шалгагч нар зайны болон газар дээрх хяналт шалгалтаар байнгын хяналт тавина.

14.7. Хороо тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгосны дараа тухайн тохиромжтой этгээдийн шаардлага хангахгүй болсон этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

14.8. Удирдах албан тушаалтан өөрчлөгдснөөр түүнийг түр орлон гүйцэтгэх этгээд томилогдсон тохиолдолд тухайн этгээд нь тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байна.

### **Арван тав. Хяналт хариуцлага**

15.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

15.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж холбогдох хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

*Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны дугаар сарын -ны өдрийн  
дугаар тогтоолын 6 дугаар хавсралт*



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдрийн \_\_\_\_\_ дугаар тогтоолоор \_\_\_\_\_-д

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

Энэхүү гэрчилгээ нь  
хавсралтын хамт  
хүчинтэй



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

\_\_\_\_\_ ТООТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад зориулсан тэмдэглэлүүд

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй).

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: \_\_\_\_\_

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ГУРАВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл олгосон огноо	Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн угаар

ДӨРӨВ. Мэргэжлийн байгууллагын салбарын тэмдэглэл:

Д/д	Салбарын хаяг	Хаягийн өөрчлөлт	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар


ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

ЗУРГАА. Хувьцаа эзэмшлийн талаар:

Д/д	Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эзэмшлийн дүн	Хувь	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг

Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны дугаар сарын -ны өдрийн  
дугаар тогтоолын 7 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН  
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .  
. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдрийн \_\_\_\_ дугаар тушаалыг үндэслэн \_\_\_\_\_ хот/аймаг дахь \_\_\_\_\_ тоот регистрийн дугаар бүхий \_\_\_\_\_ тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй \_\_\_\_\_ оноосон нэр бүхий ХХК-д

(Мэргэжлийн байгууллагын салбарын нэр)

байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

*Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны дугаар сарын -ны өдрийн  
дугаар тогтоолын 8 дугаар хавсралт*

## **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДАХЬ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН DOOD ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийн доод хэмжээ, норматив:

- 1) Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа – 100,0 сая төгрөг.;
- 2) Брокерын үйл ажиллагаа – 200,0 сая төгрөг.;
- 3) Дилерийн үйл ажиллагаа – 300,0 сая төгрөг.;
- 4) Андеррайтерийн үйл ажиллагаа – 1.000,0 сая төгрөг.;
- 5) Дээрх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэг зохицуулалттай этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлж тооцно.
- 6) Энэхүү өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийн доод хэмжээний норматив нь 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх ба 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэхэд 2.000,0 сая төгрөгийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллана.

7) Брокер, дилер, андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд нь өөрийн хөрөнгийн далаас доошгүй хувийг мөнгөн хөрөнгө, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “А” ангилалд хамаарах хувьцаа, Засгийн газрын богино хугацаат үнэт цаасаар бүрдүүлнэ, Үнэт цаас нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

ТӨСӨӨЛ